



MFWA

МОНГОЛЫН ГЭР БҮЛИЙН
САЙН САЙХНЫ НИЙГЭМЛЭГ

**МОНГОЛЫН ГЭР БҮЛИЙН САЙН
САЙХНЫ НИЙГЭМЛЭГИЙН ДҮРЭМ**

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл. Оноосон нэр, зохион байгуулалтын хэлбэр

1.1 Байгууллагын оноосон нэр:

а) Бүрэн нэр “Монголын Гэр бүлийн сайхны нийгэмлэг” ТББ /цаашид энэхүү дүрэмд цаашид “Нийгэмлэг” гэнэ./

б) Товчилсон нэр: “МГБССН” ТББ

1.2 Зохион байгуулалтын хэлбэр

1.2.1. Нийгэмлэг нь Олон Улсын Гэр Бүл Төлөвлөлтийн Холбооны Монгол улс дахь гишүүн, ашгийн төлөө бус, нийгэмд үйлчилдэг төрийн бус байгууллага болно.

1.2.2. Иргэний хууль, Төрийн Бус Байгууллагын тухай Монгол Улсын хууль, болон холбогдох бусад хууль тогтоомж, Олон Улсын Гэр Бүл Төлөвлөлтийн Холбооны бодлого зорилго стандартуудад нийцүүлэн баталсан энэхүү дүрмийг үйл ажиллагаандаа удирдлага болгон ажиллана.

1.2.3. Нийгэмлэг нь 1994 онд үүсгэн байгуулагдсан ба үүнээс хойш 2001, 2003, 2007, 2010, 2013, 2016, 2017, 2018, 2021 онуудад дүрмэнд шинэчилсэн найруулга хийж, нэмэлт өөрчлөлт оруулсан болно.

1.2.4. Нийгэмлэгийн төв нь Улаанбаатар хотод байрлана. Нийгэмлэг нь Монгол улсын Аймаг, Нийслэл, дүүрэг, сум зэрэг засаг захиргааны нэгжүүдэд салбар, төлөөлөгчийн газартай байж болно.

2 дугаар зүйл. Нэр томъёоны тодорхойлолт

2.1. Энэ дүрэмд хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурьдсан утгаар ойлгоно:

2.1.1. “**Бүх гишүүдийн хурал**” гэж энэхүү дүрмэнд заасан эрх, үүргийг хэрэгжүүлэх нийгэмлэгийн эрх барих дээд байгууллагыг;

2.1.2. “**Удирдах зөвлөл**” гэж бүх гишүүдийн хурлаас сонгогдсон энэхүү дүрмийн хүрээнд үйл ажиллагаа явуулах засаглалын нэгжийг;

2.1.3. “**Ерөнхийлөгч**” гэж нийгэмлэгийн гадаад, дотоодод төлөөлөх, удирдах зөвлөлийн хуралдааныг даргалах, удирдах зөвлөлийн шийдвэрийг үндэслэн гүйцэтгэх захиралтай гэрээ байгуулах зэрэг бүрэн эрхтэй бүх гишүүдийн хурлаас сонгогдсон хүнийг;

2.1.4. “**Хяналтын зөвлөл**” гэж бүх гишүүдийн хурлаас сонгогддог, Удирдах зөвлөл болон Гүйцэтгэх захирлын үйл ажиллагаанд бүх гишүүдийн нэрийн өмнөөс хяналт тавих бөгөөд бүх гишүүдийн хуралд ажлаа тайлагнах үүрэг бүхий хяналтын нэгжийг;

2.1.5. “**Гүйцэтгэх захирал**” гэж удирдах зөвлөлөөс томилж, Удирдах зөвлөлийн олгосон эрх хэмжээний хүрээнд төрийн бус байгууллагыг өдөр тутмын удирдлагаар хангах, төлөөлөх, өмч хөрөнгийг захиран зарцуулах эрх бүхий албан тушаалтан;

2.1.6. “**Ажлын алба**” гэж нийгэмлэгийн өдөр тутмын үйл ажиллагааг төлөвлөж удирдан чиглүүлэх үүрэг бүхий гүйцэтгэх захирлаар ахлуулсан албыг ;

2.1.7. “**Салбар**” гэж энэхүү дүрмийн хүрээнд зохих журмын дагуу байгуулагдсан нэгжийг;

2.1.8. “**Гишүүн**” гэж Нийгэмлэгийн зорилт, бодлого үйл ажиллагааг хүлээн зөвшөөрсөн, дүрэмд заасан журмын дагуу гишүүнээр элссэн гишүүдийг;

2.1.9. “**Сонгуульт албан тушаалтнууд**” гэж Удирдах зөвлөлийн болон Хяналтын зөвлөлийн гишүүд, Удирдах зөвлөлийн дарга, Санхүүчийг ойлгоно.

ХОЁРДУГААР БҮЛЭГ НИЙГЭМЛЭГИЙН ЗОРИЛГО, БАРИМТЛАХ ЗАРЧМУУД

3 дугаар зүйл. Нийгэмлэгийн зорилго

3.1 Бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэнд ба эрхийн талаар боловсрол олгох, тусламж үйлчилгээ, үйл ажиллагааг хүртээмжтэй чанартай үр дүнд суурилсан төлөвлөгөөний дагуу зохион байгуулж хэрэгжүүлдэг тэргүүний төрийн бус байгууллага байхыг эрмэлзэнэ. Нийгэмлэг нь энэхүү зорилгодоо хүрэхийн тулд Олон Улсын Гэр Бүл Төлөвлөлтийн Холбоо/ОУГАТХ/-ны гишүүний хувьд түүний чиглэл, үйл ажиллагааны зорилтыг баримталж, бэлгийн ба нөхөн үржихүйн эрүүл мэнд, ба эрхийн мэдлэг, боловсрол эзэмших, үйлчилгээ авах нь хүний үндсэн эрх бөгөөд хүний аз жаргал, хөгжил дэвшил, энх тунх байдлын зайлшгүй нөхцөл гэж үзэж доорхи зорилтыг дэвшүүлж ажиллана:

3.1.1 Бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэнд, эрхийн талаарх мэдлэг, боловсрол эзэмших, мэдээлэгдсэн үйлчилгээг чөлөөтэй сонгох нь хүний үндсэн эрх мөн болохыг ухуулан сурталчилж олон нийтэд таниулах

3.1.2 Бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэнд ба эрхийн талаарх боловсрол тусламж үйлчилгээ үйл ажиллагааг хүн бүрт хүртээмжтэйгээр хүргэх

3.1.3 Бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн эрхийн талаарх боловсрол тусламж үйлчилгээ үйл ажиллагааг нотолгоонд суурилан төлөвлөж хэрэгжилтийг хангах

3.1.4 Бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэнд ба эрхийн талаарх боловсрол тусламж үйлчилгээ үйл ажиллагааныхаа үр дүнг тогтмол үнэлж сайжруулах

4 дүгээр зүйл: Баримтлах зарчмууд

Нийгэмлэг нь зорилго зорилтдоо хүрэхийн тулд дараах зарчмуудыг баримтална:

4.1 Бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэнд эрхийн талаарх тусламж үйлчилгээ, үйл ажиллагаандаа Монгол улсын холбогдох хууль тогтоомж болон ОУГБТХ-ны стандартыг мөрдөх

4.2 Бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэнд ба эрхийн талаарх боловсрол тусламж үйлчилгээ үйл ажиллагаагаа сайн дурын үндсэн дээр, хувь хүний сонголтыг хүндэтгэн үзүүлэх

4.3 Бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэнд эрхийн талаарх тусламж үйлчилгээ, үйл ажиллагааг хэрэгжүүлэхдээ Монгол улсын төр, засгийн болон төрийн бус, олон нийтийн, хувийн хэвшил, хэвлэл мэдээллийн мөн олон улсын байгууллагуудтай өргөн хүрээнд хамтран ажиллах

4.4 Бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэнд эрхийн талаарх боловсрол тусламж үйлчилгээ, үйл ажиллагаа хэрэгжүүлэхдээ арьс өнгө, яс үндэс, нас хүйс, улс төрийн болон шашны итгэл үнэмшил, хөгжлийн бэрхшээл, бэлгийн чиг баримжаа, хүйсийн баримжаа илэрхийлэл, нийгэм эдийн засгийн байдал, газарзүйн байршлаар ялгаварлан гадуурхахгүй жендэрийн тэгш байдлыг хангах

4.5 Бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэнд эрхийн талаарх боловсрол тусламж үйлчилгээ, үйл ажиллагааг эмзэг бүлгийн, алслагдсан, орлого багатай, хүмүүст илүүтэй хүргэж ажиллахад анхаарах

4.6 Улс төр, шашны байгууллагаас ангид, бие даасан байх, улс төрийн нам эвсэл, хөдөлгөөн, сонгууль болон шашны үйл ажиллагаанд аливаа хэлбэрээр оролцохгүй байх

ГУРАВДУГААР БҮЛЭГ САНХҮҮЖИЛТ, САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТ

5 дугаар зүйл: Санхүүгийн эх сурвалж

5.1 Нийгэмлэг нь дэвшүүлсэн зорилго зорилтууддаа хүрэхийн тулд үйл ажиллагаандаа шаардлагатай санхүүжилтийг дараах эх үүсвэрээс бүрдүүлнэ.

5.1.1 Төрийн, төрийн бус байгууллага, олон улсын, бусад байгууллагын төсөл хөтөлбөрийн санхүүжилт;

5.1.2 Гишүүний татвар, хандив;

5.1.3 Монгол улсын хууль тогтоомж зөрчөөгүй, нийгэмлэгийн зорилгод үл харшлах иргэд, аж ахуйн нэгж байгууллагын хандив, өв, бэлэг, санхүүгийн дэмжлэг, ажлын хөлс;

5.1.4 Дүрмийн зорилгоо хэрэгжүүлэхтэй холбогдсон аж ахуйн үйл ажиллагаанаас олсон орлого;

5.1.5 Нийгэмлэг нь зорилго зорилтуудаа хэрэгжүүлэхэд шаардлагатай зээл авах;

6 дугаар зүйл: Нийгэмлэгийн зарлага

6.1 Нийгэмлэгийн бүх орлого, тоног төхөөрөмж, эд хөрөнгө нь зөвхөн энэ дүрмийн 2 дугаар бүлэгт заасан зорилго, зорилтууд ба зарчмуудыг биелүүлэхэд зориулагдана.

6.2 Нийгэмлэгийн орлогоос нийгэмлэгийн удирдах зөвлөлийн гишүүн, нийгэмлэгийн ажилтан, аль нэг гишүүнд ногдол ашиг хуваарилах, хөрөнгийн баталгаа гаргах, тэдгээрийн төлбөрийг төлөх, тоног төхөөрөмж, эд хөрөнгийн аливаа хэсгийг ашгийн зорилгоор шууд ба шууд бусаар шилжүүлэх буюу өгөхийг хориглоно.

6.3 Нийгэмлэгийн удирдах зөвлөлийн гишүүн, ажилтан, аль нэгэн гишүүн нийгэмлэгийн эд хөрөнгөөр хувийн ашиг олох зорилгоор санхүүгийн буюу аж ахуйн үйл ажиллагаа явуулахыг хориглоно.

6.4 Нийгэмлэгийн удирдах зөвлөл, ажлын алба, салбар, нь Улсын их хурал, Ерөнхийлөгчийн болон иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуульд нам эвсэл нэр дэвшигчдэд эд хөрөнгө хандив өгөхийг хориглоно.

7 дугаар зүйл: Санхүүгийн хяналт шалгалт

7.1 Нийгэмлэгийн санхүүгийн үйл ажиллагаанд жил бүр аудитын хяналтыг ОУГБТХ-ны санхүүгийн бодлогын дагуу ОУГБТХ-ноос зөвшөөрөгдсөн Удирдах Зөвлөлөөс томилсон хөндлөнгийн хяналтын байгууллагаар хийлгүүлнэ.

7.2 Хөндлөнгийн хяналт хийсэн байгууллага нь аудитын тайлангаа Удирдах Зөвлөл, болон Хяналтын зөвлөлд танилцуулж тайлагнана.

7.3 Хөндлөнгийн хяналтын тайланг Нийгэмлэгийн төв байранд эсвэл Удирдах зөвлөлөөс тогтоосон байранд архивлана.

7.4 Тайланг гишүүдэд нээлттэй танилцуулж, Нийгэмлэгийн цахим хуудсанд байршуулна.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ НИЙГЭМЛЭГИЙН ГИШҮҮНЧЛЭЛ

8 дугаар зүйл: Гишүүнчлэл

8.1 Нийгэмлэгийн зорилт, бодлого үйл ажиллагааг хүлээн зөвшөөрсөн, Монгол улсын иргэн ба Монгол улсын нутаг дэвсгэрт хууль ёсоор оршин суугаа гадаадын иргэн нь сайн дурын үндсэн дээр нийгэмлэгийн зохих журмын дагуу Нийгэмлэгт гишүүнээр элсэж болно.

8.2 Нийгэмлэгт гишүүнээр элсэх хүсэлт гаргасан иргэнийг арьс өнгө, яс үндэс, нас хүйс, улс төрийн үзэл бодол, шашин шүтлэг, хөгжлийн бэрхшээл, бэлгийн чиг баримжаа, хүйсийн баримжаа илэрхийлэл, нийгэм эдийн засгийн байдал, газарзүйн байршлаар нь ялгаварлан гадуурхах, эрх чөлөөг нь хязгаарлахыг хориглоно.

8.3 Нийгэмлэг нь гишүүдийн нийгмийн бүлэг, нутаг дэвсгэрийн төлөөлөл, мэргэжил, хүйс, насны тэнцвэрт байдлыг харгалзана.

8.4 Нийгэмлэгийн гишүүнд үнэмлэх олгож болно. Үнэмлэхний загварыг удирдах зөвлөлөөс батлана.

9 дүгээр зүйл: Гишүүдийн ангилал

9.1 Энгийн гишүүн: Тус нийгэмлэгт гишүүнээр элсэж, жилийн татвараа төлсөн, нийгэмлэгийн үйл ажиллагаанд идэвхтэй оролцох, бүх гишүүдийн хуралд төлөөлөгчөөр сонгогдон саналын эрхтэй оролцох эрхтэй хүнийг хэлнэ.

9.2 Дэмжигч гишүүн: Татвар төлдөггүй боловч нийгэмлэгийн үйл ажиллагаанд өөрийн мэргэжил боловсрол ур чадвараараа дэмжлэг үзүүлж, идэвхтэй оролцдог, бүх гишүүдийн хуралд төлөөлөгчөөр сонгогдон оролцох эрхгүй хүнийг хэлнэ.

9.3 Онцгой гишүүн: Удирдах Зөвлөлөөс тогтоосон татварыг төлсөн, нийгэмлэгийн үйл ажиллагаанд бодит санхүүгийн дэмжлэг үзүүлдэг, бүх гишүүдийн хуралд төлөөлөгчөөр сонгогдон саналын эрхтэй оролцох эрхтэй гишүүнийг хэлнэ.

9.4 Хүндэт гишүүн: Нийгэмлэгийн үйл ажиллагаанд 10-аас дээш жил идэвхтэй оролцож бодит хувь нэмэр оруулсан, аймаг, хотын салбараас тодорхойлогдсон, Удирдах зөвлөлөөс баталсан бүх гишүүдийн хуралд төлөөлөгчөөр сонгогдон оролцох эрхтэй гишүүнийг хэлнэ.

10 дугаар зүйл: Гишүүдийн эрх, үүрэг, хариуцлага, авах арга хэмжээ

10.1 Гишүүдийн эрх

10.1.1 Дэмжигч гишүүнээс бусад гишүүн нь бүх гишүүний хуралдаанд төлөөлөгчөөр нэр дэвших, төлөөлөгчөөр сонгогдох, бүх гишүүдийн хуралд төлөөлөгчөөр сонгогдсон тохиолдолд салбараа төлөөлөн бүх гишүүний хуралд оролцож үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхтэй.

10.1.2 Дэмжигч гишүүнээс бусад гишүүн нь бүх гишүүдийн хуралд төлөөлөгчөөр сонгогдсон тохиолдолд бүх гишүүдийн хурлаас сонгогдох сонгуульт албан тушаалтныг сонгоход саналаа өгөх, мөн сонгогдох сонгуульт албан тушаалтанд сонгогдох эрхтэй.

10.1.3 Гишүүд нь удирдлагын гаргасан шийдвэр болон санхүүгийн тайлантай танилцах эрхтэй.

10.1.4 Нийгэмлэгээс зохион байгуулсан аливаа арга хэмжээ, ажил үйлчилгээнд оролцох, үйлчлүүлэх болон журмаар тогтоосон хөнгөлөлт эдлэх боломжтой.

10.1.5 Гишүүн нь Нийгэмлэгийн гишүүнээс хүссэн үедээ татгалзах эрхтэй.

10.2 Гишүүдийн үүрэг

10.2.1 Гишүүд нь Монгол Улсын хууль, тогтоомж, Олон Улсын Гэр Бүл Төлөвлөлтийн Холбооны бодлого зорилго стандарт, Нийгэмлэгийн дүрэм, үйл ажиллагаандаа баримтлах бодлого, журмыг дагаж мөрдөх, дэмжиж ажиллах үүрэгтэй.

10.2.2 Гишүүд нь Нийгэмлэгийн ёс зүйн дүрмээр батлагдсан ёс зүйн зарчим, ёс зүйн хэм хэмжээ, зан үйлийг мөрдөх үүрэгтэй.

10.3 Хариуцлага

10.3.1 Гишүүний ёс зүйн болон бусад зөрчлийг хяналтын зөвлөл хэлэлцэх бөгөөд хяналтын зөвлөл дүгнэлт гарган Ерөнхийлөгчид хүргүүлнэ. Ерөнхийлөгч хяналтын зөвлөлийн дүгнэлтийг үндэслэн дотоод журам болон нийгэмлэгийн ёс зүйн дүрмийн дагуу шийдвэр гаргана.

11 дүгээр зүйл: Гишүүний ашиг сонирхлын зөрчил

11.1 Удирдах Зөвлөл, Хяналтын зөвлөл, салбарын удирдах албан тушаалтнууд жил бүр ашиг сонирхлын зөрчлийн мэдүүлгийг үнэн зөв гаргаж гарын үсэг зуран Ерөнхийлөгчид хүлээлгэн өгч байна.

11.2 Гишүүн нь хувийн ашиг сонирхлыг нийгэмлэгийн ашиг сонирхлоос илүүд тавихыг хориглоно.

11.3 Гишүүн нь санхүүгийн шууд ба шууд бус сонирхлын үүднээс нийгэмлэгийн нэрээр үйлдвэрлэл явуулах, үйлдвэрлэсэн эд зүйл, материалыг бусдад худалдахыг хориглоно.

11.4 Гишүүн нь бэлэг буюу ажлын шан харамж дараах этгээдээс хүлээн авахыг хориглоно:

- Нийгэмлэгт ямар нэг эм, тоног төхөөрөмж нийлүүлдэг үйлдвэрүүдээс
- Нийгэмлэгт үйлчилгээ үзүүлдэг буюу үзүүлэх аливаа нийлүүлэгчээс

11.5 Гишүүн нь нийгэмлэгийн бүтэц, үйл ажиллагаа, эд хөрөнгийг Улсын их хурал Ерөнхийлөгчийн болон Иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгууль, нам эвсэлд нэр дэвшигчдийг дэмжих үйл ажиллагаанд ашиглахыг хориглоно.

11.6 Гишүүн нь Бүх гишүүдийн хурал, Удирдах зөвлөл, хяналтын зөвлөлийн хуралд оролцсоныхоо төлөө болон өөрийн мэргэжлийн дагуу ажил үйлчилгээ үзүүлсэн тохиолдолд цалин буюу цагийн хөлс авахыг хориглох ба гэхдээ нийгэмлэгийн үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд зайлшгүй шаардлагатай унаа, харилцаа холбоо, томилот, хоолны зардлыг зохих журмын дагуу олгоно.

11.7 Гишүүн нь нэгээс илүү сонгуульт албан тушаалд ажиллаж болохгүй.

12 дугаар зүйл: Татвар

12.1 Нийгэмлэгийн гишүүнчлэлийн татварын хэмжээг Удирдах зөвлөл тогтооно.

13 дугаар зүйл: Гишүүдийн бүртгэл

13.1 Нийгэмлэг нь төвийн болон салбарын гишүүдийн нэр, нас, хүйс, төрсөн он сар өдөр, мэргэжил, гишүүнээр элсэн орсон огноо, татвар хураамжийн төлөлт зэргийг тэмдэглэсэн гишүүдийн бүртгэлтэй байна.

13.2 Нийгэмлэгийн гишүүдийн бүртгэлийг Гүйцэтгэх захирлын ажлын алба хариуцна.

ТАВДУГААР БҮЛЭГ НИЙГЭМЛЭГИЙН УДИРДЛАГА, ХЯНАЛТЫН ТОГТОЛЦОО

14. дүгээр зүйл: Бүх гишүүдийн хурал

14.1 Нийгэмлэгийн удирдах дээд байгууллага нь Бүх гишүүдийн хурал байна.

14.2 Бүх гишүүдийн хурлыг ээлжит болон ээлжит бус хурал гэж хоёр ангилна. Ээлжит хурал нь 4 жилд нэг удаа хуралдана.

14.3 Бүх гишүүдийн ээлжит хурлыг удирдах зөвлөл товлон.

14.4 Бүх гишүүдийн хурал товлон зарласнаас хойш сонгуулийн журмын дагуу Салбарын тэргүүн салбарын хуралдааныг товлон. Хурлаар салбарыг төлөөлж бүх гишүүдийн хуралд оролцох 2 төлөөлөгчийг сонгоно.

14.5 Бүх гишүүдийн хурал нь нийт сонгогдсон төлөөлөгчдийн 60 аас дээш хувийн ирцтэйгээр хүчин төгөлдөр болно.

14.6 Бүх гишүүдийн хурлын ирц нь 60 хувь хүрээгүй тохиолдолд Ерөнхийлөгчийн шийдвэрээр 7 хоног хойшлуулж болно.

14.7 Дүрмийн 14.6-д заасан үндэслэлээр хойшилсон бүх гишүүдийн хуралд дахин ирц бүрдээгүй тохиолдолд хуралдаанд оролцсон хүмүүсийн ердийн олонхоор шийдвэр гаргах бөгөөд уг шийдвэр нь хүчин төгөлдөр болно.

14.8 Нийгэмлэгийн ээлжит бус бүх гишүүдийн хурлыг Удирдах зөвлөлийн гишүүдийн 60 аас дээш хувийн саналаар эсхүл энэхүү дүрмийн 21 дүгээр зүйлийн 21.3-д заасан үндэслэл бий болсон бол Ерөнхийлөгч тус тус зарлан хуралдуулна. Ийнхүү зарлан хуралдуулахад 14.1-14.6-д заасан журмыг баримтлана.

14.9 Бүх гишүүдийн хурлын эрх

14.9.1 Удирдах Зөвлөлийн гишүүдийг сонгох, чөлөөлөх

14.9.2 Ерөнхийлөгчийг сонгох, чөлөөлөх

14.9.3 Хяналтын Зөвлөлийг сонгох, чөлөөлөх

14.9.4 Санхүүчийг сонгох, чөлөөлөх

14.9.5 Удирдах зөвлөл болон Хяналтын Зөвлөлийн тайланг хэлэлцэх

14.9.6 Нийгэмлэгийг өөрчлөн байгуулах, татан буулгах

14.10 Бүх гишүүдийн хуралд оролцож байгаа сонгогдох эрхтэй гишүүд өөрийгөө болон аль нэг гишүүнийг Удирдах зөвлөл болон Хяналтын зөвлөл, Ерөнхийлөгчид нэр дэвшүүлэх эрхтэй.

14.11 Сонгуулийн үйл ажиллагааг Удирдах зөвлөлөөс баталсан сонгууль явуулах журмын дагуу Удирдах зөвлөлөөс томилогдсон Сонгуулийн хороо удирдан зохион байгуулна. Сонгуулийн хороо нь гурван хүнээс бүрдэх бөгөөд нэг хүн нь хуульч эрх зүйч, нэг хүн нь Удирдах зөвлөлийн гишүүн, нийгэмлэгийн ажлын албаны нэг хүн байна.

15 дүгээр зүйл: Удирдах зөвлөл

15.1 Удирдах зөвлөл” гэж бүх гишүүдийн хурлаас сонгогдсон энэхүү дүрмийн хүрээнд үйл ажиллагаа явуулах засаглалын нэгж байна.

16 дугаар зүйл: Удирдах зөвлөлийн бүрэлдэхүүн

16.1 Удирдах зөвлөлийн гишүүнээр Бүх гишүүдийн хурлаас Нийгэмлэгийн сонгуульд албан тушаалтнуудыг сонгох сонгуулийн журам болон нийгэмлэгийн дүрэмд заасан шаардлагыг хангасан хүнийг 4 жилийн хугацаагаар сонгоно. Удирдах зөвлөлийн бүрэлдэхүүн 9 хүнээс бүрдэх ба үүнээс 6 нь нийгэмлэгийн гишүүдээс, 3 нь нийгэмлэгийн гишүүн бус Хөндлөнгийн гишүүн байна. Хөндлөнгийн 3 гишүүний 1 нь эмэгтэй, нэг нь 25-аас доош насны хүн байна.

Удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнд хамаатан садан төрлийн хүмүүсийг ажиллуулахыг хориглоно.

16.2 Удирдах зөвлөлийг Ерөнхийлөгч тэргүүлнэ. Ерөнхийлөгч нь дараах тавигдах шаардлагыг хангасан байна. Үүнд:

- 16.2.1 Их дээд сургууль төгссөн дээд боловсролтой;
- 16.2.2 Тухайн салбарын үйл ажиллагаанд үнэтэй хувь нэмэр оруулсан;
- 16.2.3 Хамт олны дунд нэр хүндтэй, удирдан зохион байгуулах, багаар ажиллах, бодлогын баримт бичиг боловсруулах, дүн шинжилгээ дүгнэлт хийх чадвартай;
- 16.2.4 Гадаад хэлний зохих мэдлэгтэй; /англи, орос, хятад, бусад/
- 16.2.5 Ял шийтгэлгүй;
- 16.2.6 Нийгэмлэгийн ёс зүйн дүрмийг зөрчөөгүй байх;
- 16.2.7 Хөрөнгө нөөц бүрдүүлэх чиглэлээр ажлын туршлагатай;
- 16.2.8 Хүн ам зүй, нийгмийн бодлого, НҮЭМ-ийн асуудлаар удирдах ажлын дадлага туршлагатай;
- 16.2.9 Нийгэмлэгийн гишүүнээр 5-аас дээш жил ажилласан
- 16.2.10 Татвараа хугацаанд нь төлсөн

16.3 Удирдах зөвлөлийн гишүүдийн 50-аас доошгүй хувь нь эмэгтэйчүүд, 20-иос доошгүй хувь нь 25 хүртэлх насны залуучууд байна.

16.4 Нийгэмлэгийн гишүүдээс Удирдах зөвлөлийн гишүүдэд тавигдах шаардлага:

- 16.4.1 Гурав ба түүнээс дээш жил гишүүний үүргээ сайн гүйцэтгэн тухайн салбарын үйл ажиллагаанд тогтмол оролцсон;
- 16.4.2 Бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн чиглэлээр манлайлагч, бодлогын баримт бичиг боловсруулах, дүн шинжилгээ, дүгнэлт хийх болон удирдан зохион байгуулах, багаар ажиллах чадвартай;
- 16.4.3 Хамт олны дунд нэр хүндтэй, нийгэмлэгийн ёс зүйн дүрмийг зөрчөөгүй
- 16.4.4 Ял шийтгэлгүй;
- 16.4.5 Гадаад хэлний зохих мэдлэгтэй байх
- 16.4.6 Гишүүний татварыг хугацаанд нь тогтмол төлсөн байх;

16.5 Хөндлөнгийн удирдах зөвлөлийн гишүүнд тавигдах шаардлага:

- 16.5.1 Хөндлөнгийн удирдах зөвлөлийн гишүүд нь санхүү, нягтлан бодох бүртгэл, эдийн засаг маркетинг, олон нийттэй харилцах, бизнесийн удирдлага, эрсдлийн менежментийн, эмч, хууль, эрх зүйн мэргэжлийн болон мэргэшсэн хүмүүс байвал давуу тал болно.
- 16.5.2 Бодлогын баримт бичиг боловсруулах, дүн шинжилгээ, дүгнэлт хийх болон удирдан зохион байгуулах, багаар ажиллах чадвартай,
- 16.5.3 Ял шийтгэлгүй байх
- 16.5.4 Тухайн мэргэжлээрээ 5 буюу түүнээс дээш жил ажилласан байх
- 16.5.5 Гадаад хэлний зохих мэдлэгтэй
- 16.5.6 Удирдах зөвлөлийн гишүүд болон нийгэмлэгийн Ерөнхийлөгч, Гүйцэтгэх удирдлагатай ашиг сонирхолын зөрчилгүй байх
- 16.5.7 Сонгон шалгаруулалтад тусгайлан заасан бусад шаардлага

16.6 Нийгэмлэгийн удирдах зөвлөлийн гишүүнд 25 хүртэлх насны нэр дэвшигчид Сонгуулийн журамд заасан шалгуурыг хангасан байна.

16.7 Хөндлөнгийн удирдах зөвлөлийн гишүүд нь зөвлөлийн бүрэлдэхүүний бусад гишүүдтэй нэг адил эрх эдэлж, үүрэг хүлээнэ.

16.8 Хөндлөнгийн удирдах зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчийг сонгон шалгаруулалтын үндсэн дээр шалгаруулна. Сонгон шалгаруулалтыг Сонгуулийн хороо явуулах бөгөөд шалгуур үзүүлэлтийн шаардлага хангасан шалгарсан нэр дэвшигчдийг бүх гишүүдийн хуралд нэр дэвшүүлнэ. Хөндлөнгийн удирдах зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчдийг сонгон

шалгаруулалтын үйл ажиллагааг Удирдах зөвлөлөөс баталсан сонгуулийн журмын дагуу явуулна.

17 дугаар зүйл: Удирдах зөвлөлийн эрх, үүрэг

17.1 Удирдах зөвлөлийн эрх

17.1.1 Салбар үүсгэн байгуулах, татан буулгах

17.1.2 Нийгэмлэгийн дүрмийн шинэчилсэн найруулга, нэмэлт, өөрчлөлтийг батлах

17.1.2 Гүйцэтгэх захирлыг томилж, чөлөөлөх, Нийгэмлэгийн үйл ажиллагааг үр дүнтэй удирдан зохион байгуулахад нь гүйцэтгэх захиралд дэмжлэг тусалцаа үзүүлэх

17.1.3 Нийгэмлэгийн ажлын албаны бүтэц, зохион байгуулалт, холбогдох журмууд, түүний төсвийг батлах

17.1.4 Гүйцэтгэх захирал болон Ерөнхийлөгчийн ажлын тайлантай танилцах, үнэлэх

17.1.5 Хандивлагч байгууллагуудад хүргүүлэх төслийн санал, хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөрийн үйл ажиллагааны тайлантай танилцах, шаардлагатай тохиолдолд батлах

17.1.6 Нийгэмлэгийн байнгын, тусгай болон бусад хороод байгуулах, тайлантай нь танилцах

17.1.7 Бүх гишүүдийн ээлжит бус хурлыг зарлан хуралдуулах

17.1.8 Нийгэмлэгийн алсын хараа, зорилго, зорилтод хүрэхийн тулд ухуулга нөлөөллийн ажил зохион байгуулах, оролцох

17.1.9 Бэлгийн болон НҮЭМ, эрхийн асуудлаар онцгой хувь нэмэр оруулсан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад нийгэмлэгээс шагнал урамшуулал олгох, ОУГБТХ-ны шагналд нэрийг нь дэвшүүлэх

17.1.10 Нийгэмлэгийн дүрэм, бодлого, журам, холбогдох бичиг баримтууд нь Монгол улсын хууль болон ОУГБТХ-ны дүрэм, бодлоготой нийцэж байгаа эсэхэд хяналт тавих, үүссэн зөрчил маргааныг зохицуулах

17.1.11 Гишүүнчлэлийн татварын хэмжээг тогтоох

17.1.12 Шаардлагатай тохиолдолд гишүүдээс цуглуулах хураамж, хандивын хэмжээг тогтоох

17.1.13 Зүүн ба Зүүн Өмнөд Ази Далайн Бүсийн Зөвлөлд нийгэмлэгийг төлөөлөх хоёр гишүүнийг сонгох

17.2 Удирдах зөвлөлийн үүрэг

17.2.1 Удирдах зөвлөл нь дараах үүрэг хүлээнэ:

17.2.2 Нийгэмлэгийн нэр хүнд үнэт зүйлийг хамгаалах,

17.2.3 Нийгэмлэгийн бодлого, стратеги чиглэлийг тодорхойлох

17.2.4 Нийгэмлэгийн үйл ажиллагаанд шаардлагатай санхүүжилтын тогтвортой байдлыг хангаж, хөрөнгө нөөц бүрдүүлэх

17.2.5 Нийгэмлэгийн үйл ажиллагааны төлөвлөгөө, төсвийг батлах, хэрэгжилтэнд хяналт тавих

17.2.6 Гүйцэтгэх захирал болон ажлын алба, салбар, гишүүдэд зөвлөн туслах, дэмжих, чадваржуулах

17.2.7 Төрийн, төрийн бус, олон улсын байгууллагуудын хамтын ажиллагааны гэрээний биелэлтэнд хяналт тавих

17.2.8 Нийгэмлэгийн зорилго, зорилтод нийцсэн бодлогын баримт бичгүүд боловсруулж батлах

17.2.9 Нийгэмлэгийн санхүүгийн үйл ажиллагаанд хөндлөнгийн аудит хийх байгууллагыг жил бүр сонгож томилох, тайлантай нь танилцах

17.2.10 Нийгэмлэгийн үндсэн эд хөрөнгийг хамгаалах, санхүүгийн үйл ажиллагаанд хяналт тавих

18 дүгээр зүйл: Эрх мэдлээ шилжүүлэх

18.1 Удирдах зөвлөл нь өөрийн хэрэгжүүлэх бүрэн эрхээс Энэхүү дүрмийн 17.1.1, 17.1.2, 17.1.3, 17.1.7, 17.1.11-д зааснаас бусад эрхийг тодорхой хугацаагаар Ерөнхийлөгч болон Гүйцэтгэх захиралд тогтоол гарган шилжүүлж, олгогдсон эрхийн хүрээнд хэрэгжүүлсэн ажлын тайлан, гаргасан шийдвэрийн биелэлттэй танилцах, үнэлэх зэргээр үйл ажиллагаагаа явуулж болно.

19 дүгээр зүйл: Хяналтын зөвлөл

19.1 Хяналтын зөвлөл гэж 4 жилийн хугацаатай бүх гишүүдийн хурлаар сонгогдсон 3 гишүүний бүрэлдэхүүнтэй нэгж байна.

19.2 Хяналтын зөвлөлийн гишүүд эрүүл мэнд, санхүү, хууль эрх зүйн мэдлэгтэй, хяналт үнэлгээ хийх чадвартай гишүүд байна.

19.3 Хяналтын зөвлөл 3 гишүүнтэй байх бөгөөд үүнээс нэг хөндлөнгийн гишүүн байна. Хяналтын зөвлөлийн Хөндлөнгийн гишүүнийг энэхүү дүрмийн 16.8-д заасан журмын дагуу сонгон шалгаруулна.

19.4 Хяналтын зөвлөлийн хөндлөнгийн гишүүнд тавигдах шаардлага:

19.4.1 Санхүүгийн болон нийгэмлэгийн дүрэм журмын хэрэгжилтэд хяналт тавих, дүн шинжилгээ, дүгнэлт хийх, мэдээлэл боловсруулах, тайлагнах, явцын болон гүйцэтгэлийн хяналт шинжилгээ хийх болон удирдан зохион байгуулах, багаар ажиллах чадвартай,

19.4.2 Ял шийтгэлгүй байх;

19.4.3 Тухайн мэргэжлээрээ 5 буюу түүнээс дээш жил ажилласан байх;

19.4.4 Гадаад хэлний зохих мэдлэгтэй;

19.4.5 Удирдах зөвлөлийн гишүүдтэй болон Ерөнхийлөгч, Гүйцэтгэх удирдлагатай ашиг сонирхолын зөрчил үүсэхгүй байх;

19.4.6 Сонгон шалгаруулалтад тусгайлан заасан бусад шаардлага:

20 дугаар зүйл: Хяналтын зөвлөлийн эрх, үүрэг

20.1 Хяналтын зөвлөл нь Удирдах зөвлөлөөс олгогдсон эрхийн хүрээнд дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

20.2.1 Ээлжит болон Ээлжит бус Чуулганаас гарсан шийдвэрийн биелэлтэд хяналт тавих

20.2.2 Удирдах зөвлөл, Ерөнхийлөгч, Санхүүч, Гүйцэтгэх захирлын үйл ажиллагаанд санхүүгийн болон үйл ажиллагааны хяналт тавих

20.2.3 Нийгэмлэгийн гишүүдийн ёс зүйн зөрчлийг хянан хэлэлцэж, дүгнэлт гаргах

20.2.4 Нийгэмлэгийн эд хөрөнгийн хуримтлал, санхүүгийн үйл ажиллагаатай холбогдуулан гарсан зөрчил, гомдол, олон нийтийн мэдээллийн хэрэгслээр цацагдсан мэдээллийн дагуу хяналт, шалгалт явуулах, дүгнэлт, шаардлага гаргаж, холбогдох албан тушаалтанд хүргүүлэн, биелэлтэд нь хяналт тавих

20.2.5 Ерөнхийлөгч, Удирдах зөвлөл, Гүйцэтгэх захирал, Санхүүчийн шийдвэр, хөндлөнгийн аудиторын дүгнэлт, санхүүгийн тайлангийн талаар зөвлөмж гаргах

20.2.6 Нийгэмлэгийн санхүү болон бусад үйл ажиллагаа, түүнд хамаарах эрх зүйн баримт бичгүүдийг боловсронгуй болгох талаар санал боловсруулах;

20.2.7 Нийгэмлэгийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, заавар зөвлөмж өгөх;

20.3 Хяналтын зөвлөл нь дүрмээр олгогдсон чиг үүргээ хэрэгжүүлэхдээ Нийгэмлэгийн удирдах зөвлөл болон Ерөнхийлөгчийн үйл ажиллагааны талаар зөвлөмж бичих, шаардлагатай тохиолдолд тэдэнд Нийгэмлэгийн үйл ажиллагаанд хамаарах Монгол Улсын хууль тогтоомж, энэ дүрэмд заасан эрх хэмжээний хүрээнд шаардлага тавих эрхтэй.

20.4 Хяналтын зөвлөл нь жилд 1-ээс доошгүй удаа хуралдах ба хурлын шийдвэрийг удирдах зөвлөл, Ерөнхийлөгч, гүйцэтгэх захиралд хүргүүлж биелэлтийг хянаж ажиллана. Хяналтын зөвлөл нь цаг үеийн шаардлагаар бичгээр санал авч шийдвэр гаргаж болно. Хяналтын зөвлөлийн гишүүдийн 2 нь шийдвэрийг зөвшөөрч байгаага бичгээр илэрхийлж байгаа бол уг асуудлыг хуралдахгүйгээр саналыг хүлээн авч шийдвэр гаргаж болно.

20.5 Хяналтын зөвлөл нь ажлаа бүх гишүүдийн хуралд тайлагнана.

20.6 Хяналтын зөвлөл нь өөрийн үйл ажиллагааг хэрэгжүүлэхдээ зөвлөмж, дүгнэлт, санал, шаардлага хэлбэрээр шийдвэр гаргана.

20.7 Хяналтын зөвлөлийн гаргасан шийдвэрийг биелүүлээгүй энэхүү дүрмийн 20.2.2-д заасан албан тушаалтны талаарх шаардлагыг тухайн албан тушаалтанд хүргүүлнэ. Хэрэв шаардлагыг Гүйцэтгэх захирал биелүүлээгүй тохиолдолд Ерөнхийлөгчид, Ерөнхийлөгч, Санхүүч эсхүл Удирдах зөвлөлийн гишүүн биелүүлээгүй тохиолдолд бүх гишүүдийн хуралд тухайн зөрчлийн талаар дүгнэлт гаргаж хэлэлцүүлнэ.

20.8 Хяналтын зөвлөлийн хурлыг хяналтын зөвлөлийн дарга удирдах бөгөөд хяналтын зөвлөлийн даргыг хяналтын зөвлөл дотроосоо сонгоно.

21 дүгээр зүйл: Удирдах зөвлөл болон Хяналтын зөвлөлийн гишүүнээс татгалзах, чөлөөлөх, нөхөн сонгох

21.1 Удирдах зөвлөл, Хяналтын зөвлөлийн гишүүн нь гишүүнээс татгалзах өргөдлөө бичгээр Ерөнхийлөгчид гаргах ба өргөдөлд өөрөөр заагаагүй бол өргөдлийг хүлээн авсан өдрөөр гишүүнээс гарсанд тооцно.

21.2 Удирдах зөвлөлийн гишүүн нь үүрэгт ажлаасаа чөлөөлөгдсөн тохиолдолд үлдсэн Удирдах зөвлөлийн гишүүд бүрэн эрхийн хугацаа дуусгавар болох хүртэл үйл ажиллагааг үргэлжлүүлэн явуулна.

21.3 Удирдах зөвлөлийн тав буюу түүнээс дээш гишүүн чөлөөлөгдсөн бол Ерөнхийлөгч бүх гишүүдийн ээлжит бус хурлыг тав дахь гишүүн чөлөөлөгдсөнөөс хойш 30 хоногийн дотор зарлан хуралдуулж Удирдах зөвлөлийн гишүүний нөхөн сонгуулийг явуулна.

21.4 Хяналтын зөвлөлийн гишүүн үүрэгт ажлаасаа чөлөөлөгдсөн тохиолдолд үлдсэн гишүүд бүх гишүүдийн хурал хүртэлх хугацаанд үргэлжүүлэн үүрэг гүйцэтгэнэ. Хэрэв хяналтын зөвлөлийн гишүүд бүгд гишүүний үүрэгт ажлаасаа чөлөөлөгдсөн тохиолдолд энэхүү дүрмийн 21.3-д заасны дагуу бүх гишүүдийн ээлжит бус хурлыг зарлана.

21.5 Удирдах зөвлөл, Хяналтын зөвлөлийн гишүүн нь сонгуульт ажлаасаа татгалзан гарсан өдрөөс хойш 6 сараас дээш хугацаа өнгөрсөн тохиолдолд нийгэмлэгийн ажлын байрны сонгон шалгаруулалтанд оролцох хүсэлт гаргаж болно.

**ЗУРГААДУГААР БҮЛЭГ
УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРАЛ**

22 дугаар зүйл: Тогтмол хурал

22.1 Удирдах зөвлөл нь түүний товлосон өдөр, цаг, газарт жилд 2 удаа хуралдана.

23 дугаар зүйл: Тусгай хурал

23.1 Шаардлагатай гэж үзсэн тохиолдолд Ерөнхийлөгч Удирдах зөвлөлийн хурлыг зарлан хуралдуулж болно. Яаралтай хурлыг онлайн зарлаж болох бөгөөд саналаа бичгээр баталгаажуулж удирдах зөвлөлд хүргүүлнэ.

24 дугаар зүйл: Удирдах зөвлөлийн хурал зарлах

24.1 Ерөнхийлөгч Удирдах зөвлөлийн гишүүдийн олонхи санал гаргасан бол хурал товлон зарлах тушаал гаргах бөгөөд Удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга уг хурал болохоос 14-өөс доошгүй хоногийн өмнө Удирдах зөвлөлийн бүх гишүүдэд бичгээр мэдэгдэнэ. Энэхүү хурал товлосон мэдэгдэлд хурлаар хэлэлцэх асуудал, хурал болох өдөр, цаг, газрыг заасан байна.

25 дугаар зүйл: Хурал хүчин төгөлдөр байх

25.1 Удирдах зөвлөл гишүүдийн олонхи хүрэлцэн ирсэн тохиолдолд хурал хүчин төгөлдөр болно.

26 дугаар зүйл: Хурлын дарга

26.1 Нийгэмлэгийн Ерөнхийлөгч Удирдах Зөвлөлийн хурлыг даргална. Хүндэтгэх шалтгааны улмаас Ерөнхийлөгч хурлыг даргалах боломжгүй бол хурлыг даргалах хүнийг Удирдах зөвлөл хуралдаанд ирсэн гишүүдийн дундаас сонгоно.

27 дугаар зүйл: Удирдах зөвлөл шийдвэр гаргах

27.1 Удирдах зөвлөл шийдвэрийг хуралд оролцож байгаа санал өгөх эрхтэй нийт гишүүдийн олонхийн саналаар гаргана. Санал тэнцсэн тохиолдолд Ерөнхийлөгч нь хоёр дахь буюу эцсийн санал гаргах эрхтэй.

27.2 Энэхүү дүрмийн 27.1 дэхь заалт нь Удирдах зөвлөлөөс томилсон хороо, ажлын хэсэг зэрэг хамтын шийдвэр гаргадаг нэгжүүдэд нэгэн адил үйлчилнэ.

27.3 Цаг үеийн шаардлагаар аливаа асуудлыг Удирдах зөвлөлийн санал өгөх эрхтэй нийт гишүүдийн олонхи тухайн шийдвэрийг зөвшөөрч байгаагаа бичгээр илэрхийлж байгаа бол уг асуудлыг хуралдахгүйгээр шийдвэрлэж болно. Бичгээр санал авах ажиллагааг Ерөнхийлөгч зохион байгуулах бөгөөд саналыг хүлээн авч шийдвэр гаргана. Уг Удирдах зөвлөлийн шийдвэр дээр Удирдах зөвлөлийг төлөөлж Ерөнхийлөгч гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болно.

27.4 Энэхүү дүрмийн 27.3 дахь заалт нь Удирдах зөвлөлөөс томилсон бусад хороо, ажлын хэсэгт зэрэг хамтын шийдвэр гаргадаг нэгжүүдэд нэгэн адил үйлчилнэ.

27.5 Ийнхүү бичгээр гаргасан шийдвэрийг Удирдах зөвлөл, Хяналтын зөвлөл буюу зохих хороо, ажлын хэсгийн хурлын тэмдэглэлд хавсаргана.

28 дүгээр зүйл Итгэмжлэл хэрэглэх

28.1 Удирдах зөвлөлийн гишүүн нь тодорхой шалтгааны улмаас хуралд оролцох боломжгүй тохиолдолд Удирдах Зөвлөлийн өөр нэг гишүүнд өөрийн санал өгөх эрхээ итгэмжлэн шилжүүлнэ. Итгэмжлэлийг бичгээр гаргаж он сар өдөр, гарын үсэг зурсан байх ба уг итгэмжлэл нь зөвхөн тухайн хуралд хүчин төгөлдөр байна.

28 дугаар зүйл: Хурлын тэмдэглэл

28.1 “Удирдах зөвлөл, Хяналтын зөвлөлийн хурлын үйл явцыг нарийн бичгийн дарга, ажлын албатай хамтран тэмдэглэл хөтөлнө. Нарийн бичгийн даргыг Удирдах Зөвлөл, Хяналтын зөвлөлийн хурлаас нэг гишүүнийг сонгон томилно. Хурлын тэмдэглэлийг хурлаас хойш 14 хоногийн дотор Удирдах Зөвлөл, Хяналтын гишүүдэд илгээх ба тогтоол дээр бүх гишүүд, тэмдэглэл дээр нарийн бичгийн дарга, хурал даргалагч гарын үсэг зурна. Удирдах зөвлөл, Хяналтын зөвлөл хурлын холбогдох шийдвэрийг салбар, хороо, ажлын хэсэгт бичгээр хүргүүлнэ.

29 дугаар зүйл. Удирдах зөвлөл, Хяналтын зөвлөлийн бүрэн эрхийн хугацаа

29.1 Удирдах зөвлөл, Хяналтын зөвлөлийн бүрэн эрхийн хугацаа нь 4 жил байна. Удирдах зөвлөл, Хяналтын зөвлөлд 2 удаа сонгогдсон нийгэмлэгийн гишүүн дөрвөн жилийн хугацаагаар завсарласны дараа Удирдах зөвлөл, Хяналтын зөвлөлийн гишүүнээр дахин нэг удаа сонгогдох эрхтэй. Удирдах зөвлөл, хяналтын зөвлөлийн гишүүний нийт ажиллах хугацаа 12 жил байна.

29.2 Удирдах зөвлөл, Хяналтын зөвлөлийн гишүүний бүрэн эрх нь Сонгуулийн хорооны шийдвэр гаргаж шийдвэрийг бүх гишүүдийн хурлаар баталснаар сонгогдсонд тооцож бүрэн эрх нь хэрэгжиж эхлэнэ. Бүх гишүүдийн хурлын шийдвэр дээр хуралдаан даргалагч гарын үсэг зурна.

29.3 Удирдах зөвлөлийн бүрэн эрхийн хугацаа дуусах сүүлийн жилд бүх гишүүдийн хурлыг зайлшгүй зарлан хуралдуулж Удирдах зөвлөлийн гишүүний сонгууль явуулна.

29.4 Нэг хүн нэгээс илүү сонгуульд албан тушаалд ажиллаж болохгүй.

29.5 Нийгэмлэгийн ажилтнууд сонгуульд санал өгөх болон сонгогдох эрхгүй байна.

ДОЛДУГААР БҮЛЭГ СОНГУУЛЬТ АЛБАН ТУШААЛТАН

30 дугаар зүйл: Ерөнхийлөгч

30.1 Ерөнхийлөгчийг бүх гишүүдийн хурлаас 4 жилийн хугацаагаар сонгоно.

30.2 Ерөнхийлөгч нь Удирдах зөвлөлийн дарга байхаас гадна дараах үүрэг, хариуцлага хүлээнэ.

30.2.1 Нийгэмлэгийн бодлого боловсруулах үйл явцад Удирдах Зөвлөлийн гишүүдийг удирдан чиглүүлэх

30.2.2 Удирдах зөвлөлийн нэрийн өмнөөс Нийгэмлэгийн үйл ажиллагаанд хяналт тавих

30.2.3 Удирдах зөвлөл, Бүх гишүүдийн хурлыг даргалах

30.2.4 Нийгэмлэгийг гадаад, дотоодод төлөөлөх

30.2.5 Удирдах Зөвлөлөөр батлагдсан нийгэмлэгийн үйл ажиллагааны төсөв төлөвлөгөө хэрэгжүүлэх санхүүжилтын болон бусад холбогдох гэрээ баримт бичигт гарын үсэг зурах

30.2.6 Удирдах Зөвлөлд ажлаа тайлагнах

30.2.7 Удирдах зөвлөлөөс тодорхойлсон бусад үүргийг хэрэгжүүлэх

31 дугаар зүйл: Санхүүч

31.1 Санхүүчийг бүх гишүүдийн хурлаас 4 жилийн хугацаагаар сонгоно.

31.2 Нийгэмлэгийн Санхүүч нь дараах үүрэг хариуцлага хүлээнэ.

31.2.1 Нийгэмлэгийн санхүүгийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, хяналт тавих

31.2.2 Нийгэмлэгийн санхүү болон өмч хөрөнгийг хэрхэн бүрдүүлж, ашиглаж, зарцуулж байгаад хяналт тавих

31.2.3 Нийгэмлэгийн үйл ажиллагааны төсвийг хянах, санхүүгийн дүн шинжилгээ хийх

31.2.4 Нийгэмлэгийн санхүүгийн үйл ажиллагааны тайланг Удирдах Зөвлөлийн хуралд тайлагнах

31.2.5 Удирдах зөвлөл болон Ерөнхийлөгчөөс өгөх бусад үүргийг гүйцэтгэх

31.3 Санхүүчид тавигдах шаардлагыг Нийгэмлэгийн Сонгуульт албан тушаалтнуудыг сонгох сонгуулийн журмаар тодорхойлно.

НАЙМДУГААР БҮЛЭГ АЖЛЫН АЛБА

32 дүгээр зүйл: Ажлын алба

32.1 Ажлын алба нь Гүйцэтгэх захирал, аймгийн салбарын тэргүүн болон орон тооны бусад ажилтнуудаас бүрдэнэ.

33 дугаар зүйл: Гүйцэтгэх захирал

33.1 Нийгэмлэгийн гүйцэтгэх захирал нь дараах үүрэг хариуцлага хүлээнэ:

33.1.1 Нийгэмлэгийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан чиглүүлэх

33.1.2 Удирдах Зөвлөл, Удирдах зөвлөлийн даргатай хамтран ажиллаж сайн засаглал, үр дүнтэй менежментийг хөгжүүлэх

33.1.3 Удирдах Зөвлөлөөс баталсан үйл ажиллагааны төсөв, төлөвлөгөөний биелэлтийг хангаж ажиллах ажлыг удирдан зохион байгуулах

33.1.4 Удирдах зөвлөлд ажлаа тайлагнах

33.1.5 Удирдах зөвлөл болон Ерөнхийлөгчөөс өгөх бусад үүргийг гүйцэтгэх

34 дүгээр зүйл: Орон тооны ажилтан

34.1 Орон тооны ажилтанд Нийгэмлэгээс цалин авч байгаа бүтэн орон тоогоор ажиллаж буй бүх ажилтнууд хамаарна. Орон тооны бүх ажилтан болон салбарын тэргүүн нарыг томилж, чөлөөлж, ажлын үр дүн, хариуцлага тооцох, шагнаж урамшуулах асуудлыг Гүйцэтгэх захирал зохих журмын дагуу шийдвэрлэнэ.

35 дугаар зүйл: Ажилтны ашиг сонирхлын зөрчил

35.1 Ажилтнууд жил бүр ашиг сонирхлын зөрчлийн мэдүүлэгийг үнэн зөв гаргаж гарын үсэг зурна.

35.2 Ажилтан нь хувийн ашиг сонирхлыг нийгэмлэгийн ашиг сонирхлоос илүүд тавихыг хориглоно.

35.3 Ажилтан нь санхүүгийн шууд ба шууд бус сонирхлын үүднээс нийгэмлэгийн нэрээр үйлдвэрлэл явуулах, үйлдвэрлэсэн эд зүйл, материалыг бусдад худалдахыг хориглоно.

35.4 Ажилтан нь бэлэг буюу ажлын шан харамж дараах этгээдээс хүлээн авахыг хориглоно:

- Нийгэмлэгт ямар нэг эм, тоног төхөөрөмж нийлүүлдэг үйлдвэрүүдээс
- Нийгэмлэгт үйлчилгээ үзүүлдэг буюу үзүүлэх аливаа нийлүүлэгчээс
- Нийгэмлэгийн гишүүд, үйлчлүүлэгчид, хамтрагч түнш байгууллага, хувь хүмүүс

35.5 Ажилтан нь нийгэмлэгийн бүтэц, үйл ажиллагаа, эд хөрөнгийг Улсын их хурал Ерөнхийлөгчийн болон Иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгууль, нам эвсэлд нэр дэвшигчдийг дэмжих үйл ажиллагаанд ашиглахыг хориглоно.

35.6 Нийгэмлэг нь ажилтнууд болон гишүүдийн эхнэр, нөхөр буюу садан төрлийн хүмүүсийг нийгэмлэгт ажиллуулахгүй байх бодлого баримтлана.

ЕС ДҮГЭЭР БҮЛЭГ НИЙГЭМЛЭГИЙН САЛБАР

36 дугаар зүйл: Нийгэмлэгийн салбар

36.1 Нийгэмлэг нь зохих журмын дагуу байгуулагдсан салбартай байж болох ба засаг захиргааны нэгжийн хувьд хот/аймаг/суманд нэгдсэн нэг салбартай байна.

37 дүгээр зүйл: Аймаг/хотын салбарыг байгуулах

37.1 Нийгэмлэгийн зорилт, бодлого үйл ажиллагааг хүлээн зөвшөөрсөн, нийгэмлэгийн салбар байгуулан ажиллах хүсэлтэй 50-аас дээш хүмүүс нийгэмлэгийн зохих журмын дагуу салбар байгуулах өргөдлөө нийгэмлэгийн Удирдах Зөвлөлд ирүүлж уг асуудлыг Удирдах зөвлөлийн хурлаар шийдвэрлэнэ.

38 дугаар зүйл: Аймаг/хотын салбарын үйл ажиллагаа

38.1 Аймаг/хотын салбар нь өөрийн үйл ажиллагааг удирдан явуулах, хөтөлбөрүүдээ хэрэгжүүлэхдээ энэ дүрмийг болон зохих журмыг мөрдөж ажиллана. Аймаг/хотын салбар нь Нийгэмлэгээс тогтоосон журам зааварт нийцүүлэн үйл ажиллагаагаа явуулах бөгөөд Удирдах зөвлөлөөс баталсан дүрэм ба бодлогод захирагдана.

38.2 Салбарын үйл ажиллагааг салбарын тэргүүн удирдах бөгөөд Салбарын тэргүүнийг Гүйцэтгэх захирал томилно. Салбарын гишүүд тэргүүнд нэр дэвшүүлэх саналаа Гүйцэтгэх Захиралд гаргана.

39 дугаар зүйл: Аймаг/хотын салбарын дөрвөн жилийн тайлан сонгуулийн хурал

39.1 Аймаг/хотын салбар нь бүх гишүүдийн хурлын өмнө салбарын гишүүдийн хурлыг хийх бөгөөд салбарын гишүүдийн ээлжит хурлыг 4 жил тутамд нэг удаа зохион байгуулж дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ. Үүнд:

- Салбарын тэргүүний 4 жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг хэлэлцэх
- Салбарыг төлөөлж Бүх гишүүдийн хуралд оролцох 2 төлөөлөгчийг сонгох,
- Бүх гишүүдийн хуралд оролцох төлөөлөгчид нь гишүүний татвараа төлсөн, нийгэмлэгийн ес зүйн дүрэм зөрчиж байгаагүй, ял шийтгэлгүй гишүүн байна.

39.2 Хэрэв бүх гишүүдийн ээлжит бус хурлыг зарлан хуралдуулах шийдвэр гарсан бол ээлжит бус хурал болохоос өмнө 7 хоногийн өмнө салбарын тэргүүнүүд салбарын гишүүдийн хурлыг зохион байгуулж ээлжит бус хуралд оролцох төлөөлөгчийг сонгоно.

39.3 Салбар нь тодорхой асуудлаар хэлэлцэж шийдвэр гаргах зөвлөлтэй байж болох ба салбарууд нь эмнэлгийн орлогоос бусад дотооддоо нөөц бүрдүүлж олсон орлогоо салбарын зөвлөлийн хурлаар хэлэлцэн эрхэм зорилго, зорилтуудаа хэрэгжүүлэх, салбар болон гишүүдийг хөгжүүлэх, гишүүдийн эгнээг өргөтгөх, чадваржуулах үйл ажиллагаандаа зарцуулж болно.

39.4 Салбар нь үл хөдлөх хөрөнгө болон үндсэн хөрөнгө захиран зарцуулах эрхгүй байна.

39.5 Нийгэмлэгийн Удирдах зөвлөл, ажлын алба нь салбарын ажлын гүйцэтгэл тайлантай танилцах, гэнэтийн болон төлөвлөгөөт хяналт шинжилгээ, үнэлгээ хийх эрхтэй.

39.6 Салбарыг дараах үндэслэлээр татан буулгана. Үүнд:

1. Санхүүжилтын гэрээний биелэлтийн хувь нь 2 жил дараалан 60-аас доош
2. Гишүүнчлэл 50 хувьд хүрэхгүй \Гишүүнчлэлийн бүртгэлийг жил бүрийн 1 дүгээр сарын 20-ны дотор шинэчлэн Гүйцэтгэх захиралд хүргүүлж, гишүүнчлэлийн татварыг мөн хугацаанд бүрэн төлж баталгаажуулаагүй байх\

АРАВДУГААР БҮЛЭГ

НИЙГЭМЛЭГИЙГ ТАТАН БУУЛГАХ

40 дүгээр зүйл: Татан буулгах үндэслэл

40.1 Нийгэмлэгийг Монгол Улсын хууль болон энэхүү дүрэмд заасан журмын дагуу зөвхөн татан буулгах тухай Бүх гишүүдийн дийлэнх олонхийн шийдвэр гарсан тохиолдолд татан буулгаж болно. Нийгэмлэгийг татан буулгах асуудал хэлэлцэхийг урьдчилан зарлаагүй бол Бүх гишүүдийн ээлжит болон ээлжит бус хурлаар Нийгэмлэгийг татан буулгах талаар санал хурааж болохгүй. Татан буулгах асуудлыг хэлэлцэх бол бүх гишүүдийн хуралд хэлэлцэх асуудалд уг асуудлыг заавал оруулж бүх гишүүдийн хурлын төлөөлөгч нарт мэдэгдсэн байна.

40.2 Бүх гишүүдийн хурлаас татан буулгах шийдвэр гарсан бол Нийгэмлэгийг татан буулгах коммисыг мөн сонгож томилох бөгөөд татан буулгах коммисын ажиллах хугацаа, татан буулгахад гарах зардал, комисст төлөх төлбөрийн хэмжээ зэргийг тогтоолд заана.

40¹ дугаар зүйл: Татан буулгасны дараа үлдэх эд хөрөнгө

40^{1.1} Нийгэмлэгийг татан буулгах тохиолдолд өр зээлээ төлж, санхүүгийн үүргээ гүйцэтгэж дууссаны дараа үлдэх эд хөрөнгийг Нийгэмлэгтэй ижил төстэй үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагад шилжүүлэх буюу хууль тогтоомжид заасны дагуу татан буулгах комисс шийдвэрлэнэ.

АРВАН НЭГДҮГЭЭР БҮЛЭГ ДҮРЭМД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ, ДҮРМИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫГ БАТЛАХ, БҮРТГҮҮЛЭХ

41 дүгээр зүйл: Дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах, дүрмийн шинэчилсэн найруулгыг батлах

41.1. Удирдах зөвлөлийн гишүүн, Хяналтын зөвлөлийн гишүүн, Гүйцэтгэх захирал нь дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах санал гаргах эрхтэй бөгөөд саналаа холбогдох үндэслэлийн хамт бичгээр гарган Удирдах зөвлөлд хүргүүлнэ.

41.2. Удирдах зөвлөл саналыг бүх салбарт хүргүүлэн, хэлэлцүүлж дийлэнх олонхи уг саналыг дэмжсэн тохиолдолд Удирдах зөвлөлийн хурлаар шийдвэрлэнэ.

41.3. Дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах, дүрмийн шинэчилсэн найруулгыг батлах тухай шийдвэр гарснаас хойш улсын бүртгэлд бүртгүүлнэ.

1. 2001 оны 9 сарын 12-ны Төлөөлөгчдийн Хоёр Жилийн хурлаар хэлэлцэн шинэчлэн батлав.
2. 2003 оны 10-р сарын 18-ны өдрийн Төлөөлөгчдийн Хоёр Жилийн хурлаар хэлэлцэн шинэчлэн батлав.
3. 2007 оны 9 дүгээр сарын 7-ны өдрийн Төлөөлөгчдийн Хоёр Жилийн хурлаар хэлэлцэн шинэчлэн засварлаж батлав.
4. 2010 оны 9 дүгээр сарын 24-ны өдрийн Төлөөлөгчдийн Гурван жилийн хурлаар хэлэлцэн шинэчлэн засварлаж батлав.
5. 2013 оны 9 дүгээр сарын 14-ний өдрийн Төлөөлөгчдийн гурван жилийн хурлаар хэлэлцэж батлав.
6. 2016 оны 10 дугаар сарын 29-ний Удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцэж батлав.
7. 2017 оны 09 дүгээр сарын 30-ны Удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцэж батлав.
8. 2018 оны 09 дүгээр сарын 30-ны Удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцэж батлав.
9. 2021 оны 11 дүгээр сарын 19-ний Удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцэж батлав.